

**ДОТООДЫН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙГ АЛБАНД ТӨЛӨВШҮҮЛЭХЭД
УДИРДЛАГЫН ҮҮРЭГ, ОРОЛЦОО**
**ROLE AND PARTICIPATION OF THE LEADERSHIP IN THE APPOINTMENT
OF INTERNAL TROOPS FORCE PERSONNEL**

Г.Мэндбаяр

Дотоод хэргийн их сургуулийн
Цагдаагийн сургуулийн Дотоодын
цэргийн албаны тэнхимийн ахлах
багш, хошууч

Хураангуй: Дотоодын цэргийн анги байгууллага, (цаашид ДЦ гэх) хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд албаны хэрэгцээ шаардлагад нийцсэн мэргэжлийн боловсон хүчин мэргэшсэн чадварлаг алба хаагч бэлтгэх, албанд төлөвшүүлэхэд офицер бүрэлдэхүүний болон удирдлагын үүрэг оролцоо, цаашид анхаарах асуудал сайжруулах, арга замыг тодорхойлох талаар санал дэвшүүлээ.

Abstract: The Internal troops Unit must train professional personnel and qualified and competent officers who meet the needs of the service to perform the functions assigned to it by law, ensure the involvement of the management team in the preparatory activities, to clarify issues to be considered further and to find a solution.

Түлхүүр үгс: Зэвсэгт хүчин, Дотоодын цэрэг, Хугацаат цэргийн алба хаагч, Цэргийн алба хаагч,

Keywords: Armed Forces, Internal Troops, Conscripts, Military Personnel,

Дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

Монгол Улсын иргэн цэргийн байгууллагад офицерын албан тушаалд цэргийн жинхэнэ алба хаахыг "офицерын алба" гэж;¹

Монгол Улсын иргэн цэрэгт бүртгэлтэй мэргэжлээр цэргийн байгууллагад ахлагчийн албан тушаалд цэргийн жинхэнэ алба хаахыг "ахлагчийн алба" гэж,²

Цэргийн байгууллагад цэргийн алба биеэр хааж байгаа монгол улсын иргэнийг;³ "Цэргийн жинхэнэ алба хаагч" гэж;

¹ Цэргийн албаны тухай хууль 3 дугаар зүйл 3.1.5 2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр

² Цэргийн албаны тухай хууль 3 дугаар зүйл 3.1.5 2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр

³ Цэргийн албаны тухай хууль 3 дугаар зүйл 3.1.5 2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр

Цэргийн албанд татагдан цэргийн байгууллагад энэ хуулиар тогтоосон хугацаанд цэргийн жинхэнэ албыг биеэр хааж байгаа иргэнийг ¹ “Хугацаат цэргийн алба хаагч” гэж;

Цэргийн байгууллагад сайн дураар гэрээгээр цэргийн жинхэнэ алба хааж байгаа иргэнийг; ² “Цэргийн гэрээт алба хаагч” гэж;

Цэргийн байгууллагад сайн дураар гэрээгээр цэргийн жинхэнэ алба хааж байгаа иргэнийг "Цэргийн гэрээт алба хаагч" гэж тус тус тодорхойлсон.³

Үндсэн хэсэг:

Монгол Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.”,

Мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг “Монгол Улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, түүнд алба хаах журмыг хуулиар тогтооно.” гэж хуульчлан баталгаажуулсан.

Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4, 13.1.6 дахь заалтаар “Төрийн тусгай албан тушаалд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам болон хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулахтай холбогдсон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдал, ... байгууллагын удирдлага, офицер, ахлагч, ... хамаарна” гэж заасан.

Цэргийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтаар цэргийн албанд “зэвсэгт хүчин⁴, хилийн⁵ ба дотоодын цэрэг⁶, онцгой байдлын байгууллага⁷-д Монгол Улсын иргэн цэргийн алба хаах үндсэн үүргийг биеэр гүйцэтгэх, эсхүл цэргийн бүртгэлд байхаар тодорхойлжээ.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгийн 7 дугаар зүйлийн 7.1-т: “Монгол Улсын төрийн цэргийн байгуулал нь тайван цагт Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагаас бүрдэнэ.⁸”, мөн зүйлийн 7.3-т: “Тайван цагт ... дотоодын цэрэг нь ... бие даасан үүрэг гүйцэтгэх бөгөөд бүтэц чиг үүргийг хуулиар тогтооно.” гэж тус тус заасныг Төр засгаас хэрэгжүүлж, Дотоодын цэргийг дахин байгуулах шийдвэр гаргаж, 2017 оны 02 дугаар сард Монгол Улсын Их Хурлаас “Дотоодын цэргийн тухай хууль”-ийг

¹ Цэргийн албаны тухай хууль 3 дугаар зүйл 3.1.8 2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр

² Цэргийн албаны тухай хууль 3 дугаар зүйл 3.1.9 2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр

³ Цэргийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2, 3.1.5, 3.1.6, 3.1.7, 3.1.8, 3.1.9, дэх хэсэг

⁴ 2016.09.01-ний Зэвсэгт хүчний тухай хууль. Төрийн мэдээлэл №36

⁵ 2016.12.28-ны Монгол Улсын хилийн тухай хууль 2017.02.01-ноос Төрийн мэдээлэл №6, 2017

⁶ 2017.02.01-ний Дотоодын цэргийн тухай хууль 2017.09.01-нд мөрдөгдсөн. Төрийн мэдээлэл №12, 2017

⁷ 5 2017.02.02-ны Гамшгаас хамгаалах тухай хууль 2017.02.27-ноос Төрийн мэдээлэл №7, 2017

⁸ Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг

баталж, Дотоодын цэргийн гүйцэтгэх чиг үүрэг, эрх зүйн үндсийг хуульчилж өгсөн.

Дээрх хуулийг 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т: “Дайны байдал зарламагц ...дотоодын цэрэг ... зэвсэгт хүчний бүтцэд багтаж үүрэг гүйцэтгэнэ¹.”, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-т: “Зэвсэгт хүчин, бусад цэрэг” гэж тус тус зааснаар “Дотоодын цэрэг нь Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага ² ” байхаар хуульчилсан байна.

Дотоодын цэргийн анги байгууллага, алба хаагч нь Дотоодын цэргийн тухай хуулийн 11.1-д заасан дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

Дотоодын цэргийн үндсэн чиг үүрэг;³

1.Дотоодын цэрэг нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1.1.улсын онц чухал объектыг хамгаалах;

1.2.нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг таслан зогсооход дэмжлэг үзүүлэх;

1.3.гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюул тохиолдсон үед болон эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

1.4.шаардлагатай үед зарим объектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч, ачаа тээшийг харгалзан хүргэх;

1.5.террорист үйлдлийг таслан зогсоох тусгай ажиллагаанд оролцох;

1.6.хуулиар тогтоосон бусад чиг үүрэг.

Дотоодын цэргийн алба хаагчийн албаны үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон нь Дотоодын цэргийн хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрэм болон цэргийн нийтлэг дүрмээр зохицуулдаг байна.

Монгол улсын засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 283 тогтоолоор батлагдсан Дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрэмд Анги, салбарт алба-ажиллагааг зохион байгуулах ажиллагааг зааж өгсөн байдаг.

Хуулийн дээрх заалтуудыг үндэслэн Дотоодын цэрэг нь тайван цагт Зэвсэгт хүчний бүтцэд хамаарахгүйгээр мэргэжлийн бие даасан үйл ажиллагаа явуулж, хуульд заасан үүргүүдийг хэрэгжүүлэхдээ Дотоодын цэргийн командлагч, штаб, мэргэжлийн анги, тусгай салбар, тусгай салаа гэсэн бүтэц, зохион байгуулалттайгаар алба-ажиллагааг явуулж байна.

¹ Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дэх хэсэг

² Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дэх хэсэг

³ Дотоодын цэргийн тухай хуулийн 11 дүгээр зүйл 11.1 дэх хэсэг

Үүнээс гадна Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.3, 4.4 дэх хэсэг Цэргийн алба хаагч ангийн байрлал, эсхүл ангийн байрлалын гадна албан үүрэг, байлдааны жижүүрлэлт, харуул, хоногийн манааны үүрэг гүйцэтгэх, ажилдаа ирэх, буцахыг албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцохоос гадна доор дурдсан нөхцөлийг албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцно:

1. Гадаад улс болон орон нутагт албан томилолтоор ажиллах;
2. Дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцах;
3. Цэргийн сургалт бэлтгэл, дайчилгаатай сургууль, цугларалтад оролцох;
4. Улсын хил, онц чухал объектыг хамгаалах;
5. Орон нутгийн хамгаалалтын арга хэмжээнд оролцох;
6. Хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг гамшгийн аюулаас аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хорио цээрийн дэглэмийг сахиулах;
7. Тэсэрч дэлбэрэх зүйл, цацраг идэвхт болон химийн хорт бодисыг аюулгүй болгох, устгах;
8. Аливаа хөнөөх хэрэгслийн хөнөөлөөс хүн ам, мал, амьтан, эд хөрөнгийг аврах, хор уршгийг арилгах;
9. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох;
10. Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох;
11. Томилгоот бусад үүрэг гүйцэтгэх.

Цэргийн албанд татагдагч цэрэг татлагын байрнаас цэргийн анги, байгууллагад хүрэх, хугацаат цэргийн албанаас бэлтгэлээр халагдсан иргэн цэргийн анги, байгууллагаас орон нутагт хүрэх хугацааг албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцдог байна.¹

Судалгааны боловсруулалт


Дотоодын цэргийн албан хаагчдын хуулиар хүлээсэн чиг үүрэг, мэргэжлийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд тэдний удирдлагын үүрэг оролцоо, манлайллыг тодорхойлох зорилгоор Дотоодын цэргийн 05, 805, 810 дугаар анги, 809, 816, 821, 822, 823, 827, 828 дугаар тусгай салбарын нийт 471 албан хаагчаас анкет асуулгын аргаар судалгаа авч, дүн шинжилгээ хийв.

Судалгаанд ахлагч бүрэлдэхүүнээс "дэд ахлагч цолтой албан хаагч 37.2%, ахлагч цолтой албан хаагч 15.9%, ахлах ахлагч цолтой албан хаагч 29.3%, нийт судалгаанд хамрагдсан албан хаагчдын 82.4% байна.

Харин офицер бүрэлдэхүүнээс дэслэгч цолтой албан хаагч 8.5%, ахлах дэслэгч цолтой албан хаагч 3%, ахмад цолтой албан хаагч 3%, хошууч цолтой албан хаагч 2.5%, дэд хурандаа цолтой албан хаагч 2 буюу 0.4%-тай хамрагджээ.


¹ Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.3, 4.4 дэх хэсэг

График. Дотоодын цэргийн албан хаагчид (Цолоор)



Тус судалгаанаас харахад судалгаанд хамрагдсан нийт бие бүрэлдэхүүний ажил үүргийн хувьд офицер бүрэлдэхүүн буюу удирдах албан тушаалтан 6.6%, гүйцэтгэх буюу ахлагч албан тушаалтан 83.7%, туслах албан тушаалтан 9.8% хамрагдсан байна.

График. Дотоодын цэргийн албан хаагчид
(Албан тушаалаар)



Дотоодын цэргийн штаб, анги, тусгай салбаруудын сүүлийн 3-5 жилийн ахлагч бүрэлдэхүүнээс гаргасан зөрчилд судалгаа хийж үзлээ.

Дотоодын цэргийн алба хаагчдаас албан үүрэг гүйцэтгэхтэй зөрчсөн сүүлийн 3 жилийн статистик сүүлийн судалгааг дараах байдлаар харуулж байна.

Дотоодын цэргийн штаб /анги байгууллага/-ын алба хаагчдын албан үүрэг
гүйцэтгэхэд гаргасан зөрчлийн хэлбэр



Зөрчлүүдийг гаргасан алба хаагчдын дийлэнх хувийг, гүйцэтгэх албан тушаалтан буюу ахлагч бүрэлдэхүүн эзэлж байгаа ба албан үүрэг гүйцэтгэж байхад ихэвчлэн дээрх зөрчлүүдийг гардаг байна.

Уг зөрчлүүдийг багасгаж бууруулах, гүйцэтгэх албан тушаалтан буюу ахлагч бүрэлдэхүүнийг албан үүрэг гүйцэтгэх, ажил албанд төлөвшүүлэхэд удирдах албан тушаалтны үүрэг оролцоо буюу офицерын манлайлал ихээхэн чухал юм.

Бие бүрэлдэхүүнийг ажил албанд төлөвшүүлэхэд удирдах албан тушаалтнаас бага бүрэлдэхүүнд албаны онцлог, хэрэгцээ, шаардлага, сонирхол, хүсэл тэмүүлэл, мэдлэг дадал, чадвартай байхыг ойлгуулж ухамсарлуулах нь зүйтэй.

Алба хаагчийн төлөвшилд тухайн хүний мэдлэг дадал чадвар, бие даах чадвар зэрэг чадваруудыг харгалзан авч үзэх хэрэгтэй.

Алба хаагчийг албанд төлөвшүүлнэ гэдэг бүр сууринаас нь эхлэн тавина гэсэн үг юм. Тийм ч учраас дотор сэтгэлээсээ ч, гаднах үйлдлээрээ ч удирдах албан тушаалтан нь өөрийн оролцоогоо харуулж байх явдал юм.

Иймд өнгөрсөн он жилүүдэд Цагдаа, Дотоодын цэргийн байгууллагаас дэвшүүлсэн зорилтод УДИРДАХ АЖИЛТНЫ МАНЛАЙЛАЛ, АЛБА ХААГЧДЫН АЖЛЫН ХАРИУЦЛАГА, ЁС ЗҮЙГ ДЭЭШЛҮҮЛЖ гэж оруулсан байдаг. Үүнээс харахад удирдлагын үүрэг, оролцоо ихээхэн харагдаж байна.

Удирдлагын зүгээс тухайн тухайн алба хаагчийг ажил албанд нь төлөвшихөд нөлөөлж буй нөлөөллийг аль болох эерэг байхаар бүрдүүлж өгөх хэрэгтэй.

Бие хүн төлөвшилийг багадаа олж авсан бол ажил албандаа төлөвших төлөвшилийг мөн ажлын эхний өдрөөс нь эерэг зөвөөр зааж сургах явдал юм.

Дээрх чадварыг эзэмшсэн алба хаагчид бусдад төлөвшсөн харагдана. Зөв төлөвшилтэй, эрдэм мэдлэгтэй, ур чадвартай, алба хаагчийг тухайн байгууллагад хүмүүжүүлдэг хүн бол удирдах алтан тушаалтан юм. Удирдах албан тушаалтан нь бие бүрэлдэхүүнд боловсрол олгох, мэргэжил эзэмшүүлэх, тэднийг ажил албанд төлөвшүүлэх үйл явцыг удирдах хамгийн зөв арга барилыг мэдэж, ашигладаг байх хэрэгтэй.

Нөгөө талаас алба хаагчид байгууллагын нэрийн хуудас болж байдаг. Сайн удирдагчаас сайн алба хаагч төрдөг. Тэдгээр алба хаагчид тухайн байгууллагаар овоглосон байдаг. Тэр ч утгаараа алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлж хандлагыг зөв чигт тогтоох нь хамгийн чухал асуудал.

Бас хэчнээн мэдлэгтэй, хэдий ур чадвартай байлаа ч сэтгэлгүй, ажилдаа хандах хандлагагүй бол дургүйд хүчгүй гэгч л болно. Удирдах ажилтан нь тухайн алба хаагчийн дутагдлыг нь зөв ойлгуулах, хандлагыг зөв зүгт чиглүүлэх нь нэн тэргүүнд бодох зүйл.

Сэтгэлзүйг нь өөрчилж байж зөв хандлага зөв төлөвшил тогтоно. Хандлага нэг чигт болсон нөхцөлд тэнд эерэг өөрчлөлт, шинэчлэлт аясаараа бий болно.

Тэгээд ч зогсохгүй удирдлага нь алба хаагчтайгаа нягт харилцаатай болж, алба хаагчаа захиалгаар сургаж, албанд дадах дадлагыг нь өөрийн материаллаг базад түшиглэн, дадлагажуулж, улам их урам зориг өгч, байвал тэр чинээгээр хүний нөөц нь улам бүр чадавхжиж, түүнийгээ дагаад зөв төлөвшинө гэж бодож байна. Мөн алба хаагчид нь өөрсдийн ажил албан тушаал дээрээ эрх үүрэг хариуцлагаа ухамсарласнаар төлөвшиж чадах юм.

Дүгнэлт:

Дотоодын цэргийн анги байгууллага, алба хаагчид хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд ажил албандаа эергээр нөлөөлж өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангах, ажил албандаа болон үүрэг гүйцэтгэлтэд сахилга ёс зүйн зөрчил дутагдал гаргахгүй байх гол шаардлага гарч байна. Иймд удирдах албан тушаалтан тухайн алба хаагчдыг албанд ирсэн өдрөөс нь өөрийн биеэр үлгэрлэн манлайлж,

зөв чиглүүлж ажил албаны онцлог үйл ажиллагааг ойлгуулан, сурган дадлагашуулж авахад удирдах албан тушаалтны үүрэг оролцоо нэн чухлыг харуулж байна.

Санал:

Удирдах албан тушаалтан офицерын манлайллыг бие бүрэлдэхүүнд байнга үзүүлж байх.

Удирдлагын зүгээс албанд төлөвших нөхцөлийг бүрдүүлэх, хүчин зүйлсийг тодотгох.

Бие бүрэлдэхүүнд ажил албанд төлөвшихөд дадлагажуулан сургагч буюу сургагч багшийг томилох. Сургагч багшийг сургаж бэлтгэх

Алба хаагчдад сургалт, соён гэгээрүүлэх ажил арга хэмжээн хамруулах.

Алба хаагчдад холбогдох хууль тогтоомж, дүрэм журам зааврын талаар болон хариуцлагын тухай сургалтуудыг зохион явуулж, алба хаагчдыг чадваржуулах.

Албандаа үлгэр жишээ, ажиллаж байгаа алба хаагчдыг удирдлагын зүгээс шагнаж урамшуулах нийтэд сурталчлах ажлуудыг зохион байгуулах саналуудын тус тус гаргаж байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Эрх зүйн актууд

1. Зэвсэгт хүчний тухай хууль. 2016 он
2. Монгол Улсын хилийн тухай хууль 2017 он
3. Дотоодын цэргийн тухай хууль 2017 он
4. Гамшгаас хамгаалах тухай хууль 2017 он
5. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль 2001 он
6. Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс

Хоёр. Ном сурах бичиг, бусад гарын авлага

1. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ хийсэн судалгааны тайлан 2023 он
2. Дотоодын цэргийн алба хаагчийн сургалтын хэрэгцээ шаардлагад хийсэн дүн шинжилгээ 2023 он

Гурав. Цахим холбоос:

<https://www.google.mn/>